

МОНГОЛ НУТГИЙН “ГАЗАР УСНЫ ЭЗЭД”

С.БЯМБАДОРЖ

МУИС-ийн. Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль, Нийгэм Соёлын Антропологиин тэнхим
e-mail: Rdorje2002@yahoo.com

Түлхүүр үг: Савдаг, Шивдаг. Цагаан өвгөн, Лус, Сан, Тахилга

Өгүүллийн товч агуулга: Уг өгүүлэлд Монгол орны “газар усны эзэд” хэмээх ойлголтын хөгжил, ламын шашин бөө мөргөлтний тэмцлийн явцад газар усны эздийн тухай ойлголт хэрхэн өөрчлөгдөн хувирч ирсэн, монголчуудын газар усны эздийн тухай уламжлалт ойлголт хийгээд шарын шашны ойлголт хоёрын харьцаа, Цагаан өвгөн, Баатрын дүрт газар усны эздийн дүрслэл, үүргийн онцлогийг тодруулан танилцууллаа.

Уул усны тайлга, тахилга гэдэг энэ их нүсэр зан үйл, ёслол чухамдаа... орчин үеийн хүний сэтгэлгээнд баахан харь хөндий, хөдхи балархай /marginal/ гэнэн хуумгай юм шиг санагдавч энэ соёл суртахууныг судалдаг дэлхийн эрдэмтдийн баталж нотолж буйгаар эрт дээр үеийн ийм төсөөлөл шинжлэх ухаан, технологийн хөгжлийн үр дүнд аажмаар бүдгэрэн мартагдаж арилна гэсэн таамаглал батлагдахгүй байгаагаар барахгүй, харин ч тэр хөгжил дэвшилтэй зэрэгцэн тодорхой хэмээр хувьсан өөрчлөгдөөд хүний сэтгэн бодох эрх чөлөөний хүрээнд оршин байх нь тод тодорхой болж байна. (Дулам, 2004: 47)

Тиймээс дээрх зан үйл, ёслолыг чухам хэнд, юунд зориулдаг, энэ үйлдвэр нь чухам хэнд юунд тустай юм бэ, энэ нь хэзээнээс инагш уламжилж ирсэн ёс болох зэрэг олон асуудал хөврөн гарна. Тиймээс энэ өгүүлэлдээ монголчуудын газар орны эзэд гэсэн ойлголтын дор чухам юу багтдаг, он цагийн явцад хэрхэн хувьсаж өөрчлөгдөж ирснийг товч авч үзэхийг оролдлоо.

Бидний өвөг дээдэс байгаль ертөнцийг сүнслэг хэмээн итгэж байсан нь яваандаа байгальд эзэн байдаг хэмээн үзэх болсон нь өнөө үед ч ардын шүтлэгийн /folk religion/ зан үйлд голлох байр эзэлсээр байна. Хэдийгээр “газар усны эзэд” хэмээх энэ ойлголт нь ард түмний оюун сэтгэлгээний хөгжлийн явцад эртний шүтлэгийн болон шашны бусад хэлбэртэй сүлэлдэн хувьсаж ирсэн ч түүний хувьслыг тодорхой хэмжээгээр ажиглаж болох юм. Монгол нутагт эртнээс оршиж байсан нүүдэлчид аль ч үед газар тэнгэр, уул усыг тахин үздэг байсан, байсаар ч байна.

Эртний Хүннүгийн тухай мэдээнд дурдсанчлан “...С тех пор как был утрачен алтарь для жертвоприношений духам земли и злаков, а в храмах предков прекратили приносить кровавые жертвы, прошло уже сорок лет” (Таскин, 1989: 40), “...Прославить волю небесных и земных духов” (Таскин, 1989: 138), “...Почитают души умерших и духов, приносят жертвы Небу, Земле, Солнцу, Луне, Звездам, созвездиям, горам, рекам и покойным старейшинам прославившимся...” (Таскин, 1989: 64) зэрэг тэдний шүтлэгийн холбогдолтой тухай мэдээ занги олонтоо

тааралдана. Гэвч дээр дурдагдсан “дух земли и злаков, небесный и земный дух” зэрэг ойлголт нь чухамдаа тодорхой газар нутгийг эрхшээсэн эзэн үү, эсвэл ерөнхий тэнгэртэй эсрэгцэх /Этүгэн эх/ газар, үржил шимийн эзэн үү гэдэг нь тодорхойгүй байгаа ба текстийн хам утгаас үзэхэд хоёрдахь утга нь илүү онож байна Дундад үеийн түүх, угсаатны зүйн дурсгал “Монголын Нууц Товчоо”нд “Tende Ögödei-qahan ebetcin gurteju aman kelen jabqan alyagdarun bö'es tölgecin-e tölgele'ülü'esü kitat irgen-ü gajar usun-u ejet hat irgen orgo-ban dawuligdarun bolagat qotod-iyān ebdekderun turgun-e adalamui...” (Rachewiltz, 1972) хэмээн дурдсан мэдээнээс үзэхэд XIII зууны монголчууд “газар усны эзэд, хаад” гэсэн ойлголттой байсныг харуулж байгаа ч энэ нь чухам орчин үеийн монголчуудын газар усны эзэд буюу савдаг/газрын эзэн/, лус/усны эзэн/ ойлголттой дүйх үү гэсэн асуулт урган гарч байна. Эртний монголчуудын анимист төсөөлөл ёсоор газар бүр, мод бүр, бут бүрт байгалийн сүнс орших бөгөөд үүнийг:

“ Бут бүр бурхан болсон
Хад бүр хан болсон
Уул бүрий онгод болсон” гэх буюу
“ Дардайн байгч уулын эзэд
Дархиран байгч усны эзэд
Арвайн байгч уулын эзэд
Сарвайн ургасан өвс модны эзэд
Урсах усны эзэд
Уйлт тохойн эзэд
Хийсэх салхины эзэд
Хэвтээ чулууны эзэд” (Дулам, 1989: 20) гэсэн үгээс ойлгож болно.

Монголын Нууц Товчоонд Чингис хаан Гурван Мэргидийн довтолгооноос амь зулбан дутааж гараад Бурхан Халдун уулыг (амиа аварсны хариуд) үеийн үед цацах, үрийн үрд тахих /шүтэх/ ам тангаргаа өгсөн тухай өгүүлдэг. Анхаарууштай нь, энд Тэмүжин Бурхан Халдун уулын эзнийг бус, Бурхан Халдун уулыг өөрийг нь шүтээн болгож байгаа нь мэдэгдэж байна. Дээрх жишээнүүдээс үзэхэд, аливаа газар орныг эрхшээн захирдаг тодорхой “эзэн”/савдаг/ гэсэн ойлголт нь өгүүлж буй үед бүрэн төлөвшин тогтоогүй байсан болов уу гэж бодож байна. Дурдагдсан “Эзэн, хан” гэсэн үг нь эдүгээ ч буриадын бөө мөргөлд “онгон-эзэн” гэсэн утгаараа хэрэглэгдэж байна. Буриадын бөө мөргөлийн “дайдын эзэд”, “хөдөөгийн эзэд” “ хаад” хэмээх ойлголтууд нь тодорхой утгаараа газар орны эзний үүрэг гүйцэтгэгч онгодууд юм. Бөө мөргөлийн үзлээр нас барсан хүчтэй бөөгийн сүнс уул хад, ус гол, ой модыг эзэгнэн сууж онгод чөтгөрүүд болон зарим хүнд ач тус болж, заримд нь хор хөнөөл учруулагч хаад, эзэд болдог байна. Мөн зарим онгод нь тэнгэрээс буумал байдаг. Жишээлбэл: “Шар улаан уулын эзэн Хуандайн хөвүүн Худалдан авагч Цолбон ноён тэнгэр, Хөх уулын эзэн Хүхүсэй ноён тэнгэр, Байгаль далайн Ойхон арал, түүний өмнөд, хойд эргийн уул хад, ус голоор байрладаг Хан Сот ноён, Ойхон уулын арын элгэн хаданд байрладаг үхлийн аюулыг сахигч Бух толгойт үнэгний хөвүүн Ажирай ноён, Бархан өндөр ууланд байрладаг Хажир цагаан ноён, Доод ангарын эзэн Ам цагаан ноён, Эрхүүгийн эзэн Хан Заргач ноён, Алтан Мундарга ууланд орших Бух ноён” (Сүхбат, 2005: 198) гм. Гэвч эдний гол үүрэг нь оршин байгаа газар усаа хамгаалан сахих явдал бус учир дагнасан үүрэгт газар усны эзэн гэж болохгүй юм.

Монголд дэлгэрсэн Ламын шашны үзэл номлол ёсоор газрын эздийг гурван үндсэн хэсэгт Орны тэнгэр /т.yul lha/, Газрын эзэн /т.sa bdag/, үндэсний эзэн /gzhi

bdag/ хэмээн хуваах ба Туган Дармабазар Лувсанчойжинима буддын шашны бурхдыг дөрөв ангилахдаа төвдийн эртний бөө мөргөлийн болон Бон шашны бурхад, ардын шүтлэгийн бурхад, газар усны эзэд, сансар огторгуйн эзэд чөтгөдийг III, IV зэрэглэлд багтааснаас бурхдын пантеоны III зэргийн нууц эздийн тоонд Орны тэнгэр, Хамт төрсөн таван тэнгэр, Савдаг, Шивдэг буюу навдаг /Орны эзэн/ ийг оруулсан байдаг. Тэрээр савдагийг түмэн тоотой байх ба голлох савдаг нь нарийн тоолбол 1000, бүдүүвчилбэл 150, товчдоо 91 тоотой байна гэжээ. Мөн савдагийг гурав хувааж болох ба :

1. Ертөнцийн туслах завсрын зүгсийг эрхшээсэн 72 савдаг
2. Дөрвөн зүг, найман зовхисыг эрхшээсэн дөрвөн савдаг Биү жин /т./-хойд зүг, Ханпан /т./-баруун зүг, Зангүн /т./-Өмнө зүг, Тэ цэ /т.зүүн зүгийн эзэн/ лугаа тариан талбай, хот балгадын суурь, мал сүргийг хашааг сахих 21 савдаг
3. Данма/т.stan ma/ тэргүүт газрын 9 савдаг гэжээ.

Шивдэгийг найман зэрэгт хуваах ба үүргээр нь уул хад, гол мөрөнд орших бирдийн зүйл, дөрвөн махбодын, орон гэрийн, уулын модны, тахилын орны, орон нутгийн, оршуулгын газрын, хот суурингийн зэрэгчлэн хуваасан байдаг (Герасимова, 1989: 37).

Үүнээс үзвэл, төвдийн буддизмын савдаг шивдгийн ойлголт нь нэлээд тодорхой системчлэгдсэн, тодорхой дүрээр, үүргээрээ ялгарсан шинжийг агуулж байна. Жишээлбэл, Баруун зүгийн газрын эзэн Ханпан хар хэмээх савдаг нь Могой толгойтой, могойн өмд өмссөн, гартаа гэрэлт цалам барьж, бар хөлөглөсөн тэргэнд залран буйгаар дүрсэлдэг. Ханпан савдаг нь баруун зүгийн газар, уул хад, ой мод, өвс ургамал, ус булаг шанд, ан амьтан, жигүүртэн шувуудыг аюул хөнөөлөөс сахин хамгаалж, хэрэв хэлмэгдүүлвээс тэрхүү хэлмэгдүүлэгчдийг дөрвөн муу зүгээс нь хорлол учруулдаг (Булган, Нямсамбуу: 136-137). Мөн төвд уламжлалд зарим савдаг усны эзэн байх нь ч бий. Жишээлбэл, Хойд зүгийн Биүжин савдаг усан цалам гартаа барьж, дун хясаат ширээн дээр залран ус гол ба нуур далайд оршин зүүн хойд зүгийн газар дэлхийг харж хамгаалдаг ба аливаа ус булаг, гол нуурын ариун дагшныг сахин харгалзан гол мөрөн, нуур далай тэнгисээр хөлөг онгоц, сал, завиар аялагчид ус ба усны ургамал, амьтныг айлган цочоох, хөнөөх, рашаан, ус нуур, гол бузарлахад дургүйцэн хилэгнэж салхи шуурга дэгдээн, давалгаа үүсгэн, хөгжөөж гэмтэн нүгэлтний амь нас, эрүүл мэндэд хөнөөл учруулна (Булган, Нямсамбуу: 137-139). Энэ мэтчилэн голлох савдгууд ихээхэн тодорхой дүрслэгдсэн байдаг онцлогтой юм. Монгол ардын билиг судлаач С.Дулам шивдэг нь “Нага буюу лусын бүлэгт хамаарах бөгөөд олонх тохиолдолд амьтан төрхтэй (зооморф) төсөөлдөг бол савдаг нь тухайн уул усны хүн төрхт (антропоморф) эзнийг хэлж байна уу” (Дулам, 2004: 51) хэмээн таамаглал дэвшүүлсэн нь сонирхолтой бөгөөд Монголчуудын аман болон бичгийн сурвалжтаас үзэхэд савдаг шивдэг хоёрыг төдийлөн ялгадаггүй нь ажиглагддаг бөгөөд ихэвчлэн бодит амьдралд савдаг гэсэн ойлголт ихэд тархмал, өөрөөр хэлбэл, Юлха, савдаг, шивдаг буюу навдаг зэрэг нь тус тусын зэрэглэл, хамрах хүрээ, үүргээр ялгаатай дүрслэгдэх боловч монгол хүний сэтгэлгээнд нэг маягаар буудаг онцлогтой. Монголчууд савдгийг зөвхөн ууланд, хуурай газарт хамааруулан ойлгох ба усны эзнийг лус (т.klu) хэмээн нэрлэдгээрээ төвдөөс ялгамжаатай байна. Монголчууд савдаг, шивдаг, лусыг “уулын тэнгэр, усны тэнгэр, орны тэнгэр” хэмээн нэрлэдэг болсон нь төвдийн “lha” хэмээх ойлголттой холбоотой. Лам нар монголчуудыг буддын шашинд оруулахын тулд бөө мөргөлтний

үндсэн шүтээн ойлголт “эх газар, эцэг тэнгэр” хэмээх ойлголтыг бүрэн халах шаардлагатай болсон. Үүний тулд төвдийн “газар усанд орших нэгэн хүмүүн бус, эзний утгат “лха” гэсэн үгийг оруулан ирж түүнээ “тэнгэр” хэмээн орчуулж заншуулжээ. Үүний улмаас эртний шүтээний нэр “тэнгэр” хэмээх үг газар усны эзэн гэсэн хоёрдогч утгатай болжээ.

Монголчуудын газар усны эздийн тухай ойлголт нь монголчуудын бэлгэдэл зүйн сэтгэлгээтэй нягт уялдсан байдаг. Хүрээний зүүн талд орших Баянзүрх хайрханыг шинжсэн шинжээч нохойгоо дагуулж яваа хуяг дуулга өмсөж, зэр зэвсгээ агссан баатар эрийн шинжтэй хэмээн харж, савдаг нь нохой байна хэмээсэн домог байдаг. Зарим домогт мэргэн харваач баатар эр (Дулам, 2004: 106) барс хөлөглөсөн тэнгэр (Дулам, 2004: 108) хэмээдэг. Хоточ сайн нохой нь монголчуудын бэлгэдлийн ёсоор айл гэрийн буян хишгийг манаж, орохыг нээж, гарахыг хааж байдаг хамгаалагч бөгөөд монгол орныг “зүгийн муу зүг”ээс ирэх, халдах хортон дайснаас хамгаалах утгыг агуулж байна. Энэ бэлгэдлийн ёсоор Богд хаант монгол улсын үеэс өнөөг хүртэл цэрэг армийн байгууллагууд (Улаанхуаран, Цагаан хуаран, Хужирбулан, Батлан хамгаалах яам гм) нийслэлийн зүүн зүгт буюу Баянзүрх хайрхны зүгт төвлөрүүлэх болсон нь монголчуудын зүг чигээр бэлгэдэх ёстой уялджээ.

Усны эзэн Лус гэдэг нь “Амьтны аймагт багтах нэгэн зүйл. Газар дор орших бөгөөд гол горхи, хур бороо, газар дэлхийг эрхшээдэг хэмээмүй. Тэднийг үймүүлбээс залхаан шийтгэдэг байна. Зарим лус номыг сахин хамгаалах ёсон буй. Буддын шашны урлагт тал биеийг нь хүнээр, тал биеийг нь могойгоор дүрслэн зурна “ хэмээн тодорхойлсон байна (Буддын шашин соёлын тайлбар толь, 2000: 52). Шаншүнгийн “Домбо шинрав “хэмээх сударт айлдахдаа “Нян хэмээх нь огторгуйд оршино. Савдаг хэмээх нь газарт оршино. Лус хэмээх нь усанд оршино” гэж номложээ (Диваасамбуу, 2006: 10). Үүнээс үзэхэд, далай нуур, мөрөн голд оршигч хийбод, зоо-антропоморф дүртэй (хүн цээжтэй могой сүүлтэй) хүмүүн бус юм. Сударт өгүүлснээр Лус нь арга билэг буюу эр эм гэсэн ялгаатай бөгөөд эр лус 360, эм лус 360, лусын хаад, хатад охид зарц, нөхөр сэлт тоо томшгүй олон байдаг ажээ. Лусыг цагаан, хар, бор, хөх, шар, ногоон, улаан, хар цоохор гэж өнгөөр нь найман аймаг болгох ба аймаг тус бүрийг язгуураар нь оноон нэрлэсэн байна. Үүнд Хааны язгуур цагаан лус, богдын язгуур шар лус, бярман язгуурын хар лус, дордсон язгуур ногоон лус, зандалчин язгуур хар цоохор лус гэнэ. Лусыг эзэгнэн буй орноор нь ангилах нь ч буй. Баруун зүгийн ууланд орших эцгийн язгуурын лус, зүүн ууланд орших тэнгэр язгуурын лус, урсгал усанд орших лус, салхинд орших лус, хот сууринд орших лус, орон гэрийн орчинд орших лус, булаг шандад орших лус гэх мэт ялгаж болно. Найман их лус нь:

1. Тааяа /т. mta'yas. ca.ananta м.Хязгааргүй/
2. Бадамгарав/т. Pad ma dkar po ca. м./
3. Жогвоо марав/т. 'jog po dmar po ca. м./
4. Бадамсэрэв/т. Pad ma ca Pad ma. м.Бадам/
5. Норжай жангү /т.nor rgyas rgyan gu. ca.vasuki м.Эд дэлгэр/
6. Дүнжон гарав/т.dung skyongs dkar po ca. sankharala м.Лавай сахигч/
7. Довжү жангү /т.stobs rgyu ca. karkatika м.хүчний шалтгаан /
8. Ригдэн онбо/т. ca.kulika м.язгуур төгс/

Зарим лус нь бурханы номыг тэтгэдэг ба Их хөлгөний үндэслэгч Богд Нагаржуна Билэг баримидын судрыг лусаас залж ирсэн гэж домоглодог. Лус

“Дуйнхор“ (Цагийн хүрд)-ын номлолыг сонсоогүй учир гол, булгийн эхэнд Дүлцэнгийн элс (Дуйнхор бурханы хот мандлыг бүтээх өнгөт элс, чулуу) өргөх нь дээд буян болдог хэмээн үздэг байна.

Буддын шашнаар дамжин орж ирсэн лус савдаг хэмээх ойлголтыг монголчууд өөрийн нүүдэлчний нөхцөл байдалд тохируулан өөрчлөн хувирган авсан нь ардын аман зохиол, билэг зүйн дурсгалаас тодорхой байна. Монгол үлгэрт лус урьд газар дээр амьдарч байгаад нэг төө биет, хоёр төө сахалт хэмээх монголын домог үлгэрийн баатарт дийлдэн усан дотор амьдрах болсон гэдэг домог ч гарсан байна (Цэрэнсодном, 1989: 47). Монголчууд лусыг аварга могой дүртэй үлгэрт дүрсэлдэг ба ардын билэг зүйд лус нь хар, цагаан хоёр янз байх ба цагаан лус нь хүн амьтанд туслан энэрч байхад хар лус нь хүнд дайсагнан ханддаг хэмээн үздэг ажээ.

Монголчуудын шүтдэг бас нэгэн байгаль, газар усны эзэн бол Цагаан өвгөн сахиус юм. “Ногоон дар эхийн тууж”д өгүүлсэнчлэн Оюу нэрт хөвгүүнийхээ байгаа газрыг зааж өгсөн уулын хар аршийг Ногоон дар эх “Дараа төрөлдөө Жимсгэнэ нэрт ууланд бухар таяг тулсан цагаан өвгөн сахиусан болж төрөхийн ерөөл тавьсан” гэдэг домог буй. Энэ сахиулсан эзэн нь савдаг шивдэг хэмээх ойлголтоос илүү өргөн, нийгэм, байгалийн үүрэгтэй ба “Газар усны эзэн цагаан өвгөний заслын судар”-т “Манзуширийн залрах Утай шингийн таван оргилт уулнаас ирсэн Цагаан өвгөн нэрт бурхан, баруун гартаа луугийн тэргүүнтэй таяг барьсан. Зүүн гартаа хүслийг хангагч чандмань эрдэнэ барьсан. Гурван ертөнцийг тойрон явагч эрдэнэсийн бүс бүсэлсэн. Жимслэг нэр ууланд суусан, сахал үс нь их цайсан шинийн хоёрон, арван зургааны өдрүүдэд ертөнцийн хүний буян хилэнцүүдийг ялган чадмуй би. Ум аа хум. Үүнийг эс чадваас би бурхан бүү болсугай” хэмээн өгүүлсэн байна. Уг сударт дурдсанаар Цагаан өвгөн нь “Хүний нас буян доройтвол нас буяныг арвижуулна, хөвгүүнгүй хүмүүс хөвгүүнийг хүсвээс хөвгүүнийг өгч хөвгүүнийг тогтоох, аян ав, жуулчлан одохуйд хэрэг үйлсүүдийг бүтээж, дайсан тогторуудыг сахиж, хар цагаан цэцэг тэргүүтэн, яр шарх зэрэг хамаг өвчнийг арилгах, үхрийн халдвар гамшиг, хонины хорхироо тэргүүтэн аливаа малын хамаг өвчин тахлыг арилгах, хүмүүний идээ их бөгөөтөл эдлэхэд хор хомс болох ба сав суулга, гэрийн дотрох аливаа эд таваар, агуурснаас өөрөө дуу гарах ба анхиалах, нохой гэр дээр гарах, хоёр эхнэр үсээ уралцахад тааралдах, чоно үг хуцах, шувуу гэр дээр гарах буюу гэрт орох, эхнэр хүүхэн унтахдаа шүдээ хавирах зэрэг есөн ес наян нэгэн муу ёрыг хариулах, уулнаас мод огтлох ба догшин газрын чулуу ухах, догшин газар буух тэргүүтэнд газар усны эздээс зайлуулах, хар цагаан хэл ам болбоос хамаг хэл амыг арилгах” тангарагтай бурхан бөгөөд үүнээс үзвэл тэрээр зөвхөн газар усыг сахих бус ард олны амьдралыг ч авран хамгаалдаг бурхан гэж үзэж болно. Буддын шашны сүм хийд бүр Цагаан өвгөн буюу Цэрэндүг бурханыг үүдэн талдаа залдаг нь нэг талаар тухайн сүм хийдийн байрлаж байгаа газрын гэмийг дарж байгаа явдал ба нөгөөтэйгүүр цагаан өвгөн сахиулсан нь өөр шашнаас орж ирсэн бурхан болохыг баталж байна. Энэ сахиулсаны атрибут нь модон таяг, тааваараа орших буга гөрөөс, элдэв шувууд байх ба Хүрээ цамд түүнийг (Цамын нэр нь Лхачинцэрэн, т.Lha chen tshe ring. м.Урт наст их тэнгэр) инээсэн байдлаар дүрсэлдэг учир нь энэ сахиулсан уурлавал хүн малын өвчин хижиг гарна гэж үздэг. Хүрээ цамын бурхадаас ганц цагаан өвгөн л тойрон үзэгч хүмүүст хүрэлцэж болдог бөгөөд түүний хүрсэн хүн тэр жилдээ эрүүл энх, аз жаргалтай байна хэмээн бэлгэшээдэг байна. Засагт хан аймгийн Ялгуусан хутагтын хүрээ, Жалханз хутагтын хүрээ зэрэг зарим хүрээ хийдэд “Бухан цам” буюу “Цагаан өвгөний цам” гаргадаг нь үхрийн мялзан өвчнийг арилгахын тухайд бөгөөд Цагаан өвгөнийг байгаль, газар усны эзнээс гадна үхэр сүргийг ивээн тэтгэгч мөн болох тул

энэ сахиулсан хилэгнэвэл мялзан зэрэг малын аюулт өвчин гарна гэж үздэгтэй холбоотой юм. Цагаан өвгөний орших орны талаар монголчуудын хувьд өвөрмөц бөгөөд Буриадад Бүрэн хан уул,, Халхад Богд хан уул, ордос монголчууд Жимст ууланд оршдог хэмээн үзэх бөгөөд баруун монголчууд хэд хэдэн газрыг цагаан өвгөнтэй холбон тайлбарладаг бол Халимагууд овоо тахилгаа цагаан өвгөн (Цагаан авга)д зориулан тахьдаг ажээ (Жуковская, 1977: 32). Монголын бөө мөргөлд ч цагаан өвгөнтэй төстэй онгод эзэд, бурхан гарвалууд байдаг. Тэдний дунд баруун өмнө зүгийн Цаст цагаан ууланд нутагтай, цагаан арслан хөлөгтэй, цагаан мөнгөн таягтай, Цагай цагаан өвгөн гэж байдаг (Сүхбат, 2005: 198). Цагаан өвгөний сан даатгалын нэгэн сударт:

“Уулын оройд нутагтай би
 Эрхэт тэнгэр оройд минь оршиж
 Этүгэн эх өлмий дор минь байдаг.
 Араатан жигүүртэн хорт могой
 Хүн мал, газрын сахиулсан усны шивдаг
 Хүр улсын хорин дөрвөн зүгийн эзэд сахиулсан
 Үзэгдэх тоо нь хичнээн олон байсан ч
 Үйлдэх үйл нь хичнээн тэрс байсан ч
 Энэ бүхнийг дарах чадал над буй
 Өндөр уулын оргилд би
 Уул усны савдаг шавдаг болдог
 Өргөн дэлгэр талд бол би
 Тарьсан тариа урсах ус болдог
 Хүн ардын дунд бол би
 Сүм хийд ус цасны эзэн
 Хот балгадын дотор бол би

Хүний суух орон, уул усны эзэн болдог” (Позднеев, 2000:84) хэмээсэн нь цагаан өвгөн нь савдаг шавдгаас ч илүү өргөн байгаль нийгмийн эзэн шинжтэй дүрслэгдэж байгаа ба дуудлагын өнгө аясаас үзэхэд бөө мөргөлийн онго шүтээн байсан нь харагдаж байдаг. Оросын эрдэмтэн А.М.Позднеев Цагаан өвгөн сахиулсанг “Хар шашны бурхан хэмээн үзсэнтэй (Позднеев, 84) санал нийлж байна. Дээр дурдсанчлан “Ногоон дар эхийн тууж”ид ч гарч буй уулын хар арш хойд насандаа Цагаан өвгөн тэнгэр болж байгаа нь ч уг сахиулсны буддын шашны өмнөх гарлыг зааж байгаа мэт. Учир нь Арш нь буддын шашны өмнөх үеийн Бярманы болон бусад шашны хатамжлагч, аглагч нарыг заасан риши хэмээх самгарди үг юм.

Монгол орны газар усны эздийн дунд ихээхэн сонирхол татах нэгэн дүрслэл байдаг нь баатрын дүрт эзэд савдаг юм. Монгол оронд морь унаж, бүрэн зэвсэг хэрэгслээ агссан, сүр жавхлант баатар эрийн дүрт савдагтай газар олон бий. Жишээлбээс: Сүхбаатар аймгийн Дарьганга сумын Баяндулаан уулын эзэн Догшин цэргийн буман аймгийн цог бадарсан, их цэргийн царай хөх, хар хөх морьтой, их эрдэнийн чимэгтэй, цусан улаан жад барьсан /О.Сүхбаатар 2001:13/ баатрын дүрээр дүрсэлдэг бол Дарьгангын Алтан овоо, Дархан хан уул, Зотол хан уул, Буриадын Бүрэнхан уулын эздийг ч зэр зэвсэгт баатар эрээр дүрсэлдэг, Улаанбаатар хотыг тойрсон дөрвөн хайрхны 3-ыг нь /Богд хан уул, Сонгино хайрхан уул, Баянзүрх хайрхан уул/ ямар нэгэн байдлаар цэргийн ноён, баатар эр савдагтай хэмээн ярилцдаг хувилбар бий. Баатрын дүрт эдгээр савдаг нь зарим судлаачдын үздэгээр Төвдийн Бихар, Далха/ Энэтхэгийн догшин бурхад төвдийн савдагтай нэгдэж нутгийн сахиус нь бурхан шашныг хамгаалагч болон хувирчээ. Жишээлбэл, төвдийн

газар усны эзэд догшин савдаг Бихар, Далха, Ловон, Тогшой, Чойжин хэмээх таван чуулган болсон “Түн-аа” хэмээх “Таван хаан” гэдэг догшин бурхан болсон гэдэг. (Нямбуу 2002: 137) зэрэг сахиусны дүрслэлтэй холбон үзэж болох ч уг үндсийг нь нэгэн цагт хүчирхэг, баатарлагаараа гайхуулж явсан монголчуудтай холбон үзэж болох мэт. “... Азийн олон орон Монгол гүрний харьяанд багтан Буддын Их хөлгөний шашин, Хятадын Күнзийн суртал, Мухаммед, Христосын шашны холбоо өргөсөн мөнхүү монгол хаад Буддын Сахьяа ёсны лам нарыг дэмжиж байснаас төвдийн хуучин Бонбын ёс, Монголын бөө мөргөл зарим талаар бие биедээ найран монгол зарим сахиус төвд нэртэй болж, төвдийн сахиусны монгол хувилбар бий болсон байна. Тэгснээс төвдийн зарим догшин сахиусны хувцас хэрэглэл нь Монголын цэрэг баатрын байдалтай болсон нь ч буй гэдэг” хэмээн угсаатан судлаач Х.Нямбуу бичжээ (Нямбуу, 2002: 138). Тиймээс баатрын дүрт монгол газар усны эздийн дүрслэлийн үндсийг төвдөөс бус, Монголын Сүлд тэнгэр, бөө мөргөлийн шүтээнүүдээс хайх нь зүйтэй юм.

Монголын Буддын шашны хөгжлийн хожуу үеийн нэгэн сонирхолтой үзэгдэл бол газар усны эздийн үүргийг шахах гэсэн оролдлого гарч эхэлж байсан гэж үзэж болно. Энэ нь сүүл үеийн зарим лам нарын бүтээлээс үзэхэд, уул овоо тахилгын зан үйлийг үйлдэхдээ газар усны эздийг нь тоочихоо больж бүрхэгдүүлэх, тахилгын судрыг нийт Монголын газар усны эздэд тохируулан хялбарчлах, эртний шүтлэгтэй уул хайрхны эзнээр буддын шашны хангал сахиусуудыг зарлах зэргээр тэмцэж байжээ. Отгон тэнгэр хайрхны эзэн нь Монголыг даагч арвис тарнийн эзэн Очирваань (т.phuag rdog м. Гартаа очирт), Хэнтий уулын эзэн ертөнцийг сахигч дөрвөн их хааны нэг Намсрай (т.mam sras), Хөгнө хан, Бага газрын чулуу уулын эзэн Улаан сахиус Жамсран (т. Lcam string) хэмээн шүтэж байжээ. Иймэрхүү үзэгдэл бусад оронд ч байсныг Утай шань уулыг Манзушир бурхны, Будаалин уулыг Жанрайсиг бурхны нутаг хэмээн алдаршуулж байснаас ажиглаж болно.

Дээр дурдсанаас эгүүлэн бодвол: Монгол орны газар усны эзэд савдаг шивдэг, лус хэмээх ойлголт нь монгол оронд буддын шашин дэлгэрсэн үеэс буюу харьцангуй хожуу аажмаар дэлгэрэн монгол орны бөө мөргөлийн болон ардын шүтлэгийн элементүүдийг өөртөө шингээн өөрчлөгдсөн байна.

Лус савдаг, шивдэг навдаг зэрэг ойлголт нь нарийн системчлэгдсэн төвдийн буддизмын ойлголт боловч монголчууд ихээхэн хялбарчлан авсан нь ажиглагдаж байна.

Монголчуудын газар усны эзэд гэсэн ойлголтод энэтхэг, төвд гаралтай хүн дүрт ба амьтан дүрт газар усны эзэд тааралдахаас гадна олонх нь монголчуудын уугуул сэтгэлгээний үндсэн дээр төлөвшсөн газар уул усны эзэд байна. Буддын шашин монголд дэлгэрэхдээ бөө мөргөлтний үндсэн шүтээн “Мөнх тэнгэр” хэмээх ойлголтыг халан шахахын тулд төвдийн эртний шүтлэгийн “лха” хэмээх ухагдахууныг оруулан ирж, түүндээ тулгуурлан “нутгийн тэнгэр, орны тэнгэр, уулын тэнгэр, усны тэнгэр” хэмээн нэрлэх болсон нь монголчуудын газар усны эздийн тухай ойлголтод тодорхой нөлөө үзүүлсэн байна.

Монголчуудын баатрын дүрт газрын эзэд нь эртний монголчуудын хүчирхэг байсан цагийн ул мөр, дурсамж болон үлдсэн сонирхолтой дүр бөгөөд хэдийгээр зарим талаар шашны бэлгэдлийн нөлөө туссан ч монголчууд-төвд-монгол хэмээх соёлын нөлөөлийн нэгэн жишээ баримт болж байгааг тэмдэглүүштэй

Монгол оронд цөөн тохиолдох шарын шашны хангал сахиус бурхад (Очирваань, Намсрай, Жамсран, Цамба) уулын эзэн болсон явдал нь буддын шашны зүгээс бөө мөргөлтөнтэй хийх тэмцлийн нэгэн хэсэг болж байна.

НОМ ЗҮЙ

- Буддын шашин соёлын тайлбар толь*, 2000. УБ.
Булган Т., Нямсамбуу Д., 2006. Овоо босгон тахих ёс ба лус савдгийн тухай. Sacred Mongolia Series. УБ.
Герасимова К.М., 1989. Традиционное верование тибетцев в культовой системе ламаизма. М., Наука.
Диваасамбуу Г., 2006. Лус савдаг, уул овоо тахилгын зан үйл. УБ.
Дулам С., 1989. Монголын домог зүйн дүр. УБ.
Дулам С., 2004. Хүрээ дөрвөн уулын тахилга, бэлгэдэл. УБ.
Жуковская Н.Л., 1977. Ламаизм и ранние формы религии. М., Наука.
Нямбуу Х., 2002. Монгол хувцасны түүх. УБ
Позднеев А.М., 2000. Очерки быта буддийских монастырей и буддийского духовенства в Монголии. Улан Уде.
Сүхбаатар О., 2001. Монголын тахилгат уул усны судар оршвой. УБ
Сүхбат Ш., 2005. Монгол нүүдэлчин ардын шашин шүтлэгийн зан үйл. УБ.
Таскин В.С., 1989. Материалы по истории кочевых народов в Китае III-Vвв. М., Наука.
Цагаан өвгөний судар. Гар бичмэл
Цэрэнсодном Д., 1989. Монгол ардын үлгэр домог. УБ.
Heissig W., 1980. The religions of Mongolia. University of California Press
Rachewiltz I.D., 1972. Index to the Secret History of the Mongols. Bloomington.

SUMMARY

S.Byambadorj

TRADITION AND EVOLUTION OF THE "LOCALITY GODS" CONCEPT OF MONGOLS

In this article, author examines transformation of category "LOCALITY GODS" existed in the shamanistic and lamaist religions, and analyzes its evolution under the conditions of the rigid fight of lamaism and shamanism. Author discusses about the relationship between traditional and Buddhist concepts of "LOCALITY GODS", *Tsagaan uvgun* (White Man), and owner of the locality in the image of warrior Hero.